

Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд 2025
оны 02 дугаар сарын 24-ны өдрийн 7142-т бүртгэсэн.



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2025 оны 02 сарын 03 өдөр

Дугаар 07

Улаанбаатар хот

“Үнэт цаасны зах зээлд арилжихаар гаргах
хадгаламжийн сертификатыг бүртгэх, арилжих,
тайлагнах журам” батлах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2, 6.2.2, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 19¹ дүгээр зүйлийн 19^{1.2} дахь хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.“Үнэт цаасны зах зээлд арилжихаар гаргах хадгаламжийн сертификатыг бүртгэх, арилжих, тайлагнах журам”-ыг хавсралтаар баталсугай.

2.Энэ тогтоолын 1-т заасан журмыг баталсантай холбогдуулан өөрийн байгууллагын холбогдох дүрэм, журамд зохих өөрчлөлтийг оруулж, Санхүүгийн зохицуулах хороогоор батламжлуулахыг “Монголын хөрөнгийн бирж” ХК, “Улаанбаатар үнэт цаасны бирж” ХК (М.Даваажаргал), “Чингис хаан хөрөнгийн бирж” ХХК (Г.Дашзэвгэ), “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК, “Монголын үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбоо” ГҮТББ (Ц.Содхүү)-д тус тус үүрэг болгосугай.

3.Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын албанд даалгасугай.

ДАРГА

Т.ЖАМБААЖАМЦ

ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛД АРИЛЖИХААР ГАРГАХ ХАДГАЛАМЖИЙН СЕРТИФИКАТЫГ БҮРТГЭХ, АРИЛЖИХ, ТАЙЛАГНАХ ЖУРАМ

НЭГ.НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Үнэт цаасны зах зээлд арилжихаар гаргах хадгаламжийн сертификат (цаашид “хадгаламжийн сертификат” гэх)-ыг Санхүүгийн зохицуулах хороо (цаашид “Хороо” гэх)-ны бүртгэлд бүртгэх, биржийн болон биржийн бус зах зээлд арилжихаар гаргах, тайлагнах, бүртгэлд өөрчлөлт оруулах, бүртгэлээс хасахтай холбоотой харилцааг энэ журмаар зохицуулна.

1.2. Хадгаламжийн сертификатыг үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллага (цаашид “арилжаа эрхлэх байгууллага” гэх), Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 69.2-т заасан мэргэжлийн холбоо (цаашид “Холбоо” гэх)-ны үнэт цаасны бүртгэлд бүртгэхтэй холбоотой харилцааг арилжаа эрхлэх байгууллага болон Холбооны холбогдох бүртгэлийн журмаар зохицуулна.

1.3. Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 5.2.4-т заасан хадгаламжийн сертификатыг мөнгөний зах зээлд гаргах, арилжихтай холбоотой харилцаа энэ журмын зохицуулалтад хамаарахгүй.

ХОЁР.ХАДГАЛАМЖИЙН СЕРТИФИКАТ ГАРГАГЧ БАНКИНД ТАВИГДАХ ШААРДЛАГА

2.1. Хадгаламжийн сертификат гаргагч банк (цаашид “банк” гэх) нь хадгаламжийн сертификатыг үнэт цаасны зах зээлд арилжихаар гаргахад дараах шаардлагыг хангасан байна:

2.1.1. Хороонд хүсэлт гаргахаас өмнөх сүүлийн хоёр жилд тогтвортой үйл ажиллагаа явуулсан байх;

2.1.2. Хороонд хүсэлт гаргах үед зээл, баталгаа, батлан даалтын гэрээгээр хүлээсэн хугацаа хэтэрсэн болон шүүхийн шийдвэрээр гүйцэтгэх өр төлбөргүй байх;

2.1.3. Банкны тухай хуулийн 6.1.1-д заасан үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлтэй байх;

2.1.4. Банкны тухай хууль тогтоомж болон Монголбанкнаас тогтоосон шалгуур үзүүлэлтийг сүүлийн нэг жилийн хугацаанд бүрэн хангасан байх;

2.1.5. Хорооноос баталсан компанийн засаглалын кодекст заасан шаардлагыг хангасан байх.

2.2. Банк нь энэ журамд заасан шаардлагыг хангаагүй бол Хороо хадгаламжийн сертификатыг бүртгэхээс татгалзах ба татгалзсан шалтгаан, нөхцөлийг тодорхой тусган банкинд энэ тухай албан бичгээр мэдэгдэнэ.

ГУРАВ.ХАДГАЛАМЖИЙН СЕРТИФИКАТЫГ БҮРТГҮҮЛЭХ ХҮСЭЛТ ГАРГАХ, ХҮСЭЛТИЙГ ХЯНАХ, БҮРТГЭХ, БҮРТГЭЛД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ, БҮРТГЭЛЭЭС ХАСАХ

3.1. Банк нь биржийн болон биржийн бус зах зээлд гаргаж буй хадгаламжийн сертификатыг бүртгүүлэх хүсэлтийг Хороо болон арилжаа эрхлэх байгууллага, Холбоонд нэгэн зэрэг гаргаж болно.

3.2. Биржийн зах зээлд гаргах хадгаламжийн сертификатыг бүртгүүлэх хүсэлтийг Хороонд гаргахдаа дараах баримт бичгийг ирүүлнэ:

3.2.1. хадгаламжийн сертификатыг бүртгүүлэх өргөдөл (энэ журмын нэгдүгээр хавсралт);

3.2.2. Төв банк (Монголбанк)-ны санал, дүгнэлт;

3.2.3. хадгаламжийн сертификатыг үнэт цаасны зах зээлд арилжихаар гаргахтай холбоотой банкны эрх бүхий этгээдийн шийдвэр;

3.2.4. арилжаа эрхлэх байгууллагын бүртгэлд бүртгэсэн тухай шийдвэр болон хадгаламжийн сертификатыг бүртгэхтэй холбоотой бэлтгэл хангагдсан тухай арилжаа эрхлэх байгууллагын тодорхойлолт;

3.2.5. хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээ, компанийн дүрэм, тусгай зөвшөөрлийн гэрчилгээний хуулбар;

3.2.6. зохицуулалтын үйлчилгээний хөлс болон улсын тэмдэгтийн хураамж төлсөн тухай баримт.

3.3. Биржийн бус зах зээлд хаалттай хүрээнд гаргах хадгаламжийн сертификатыг бүртгүүлэхэд Хороонд дараах баримт бичгийг ирүүлнэ:

3.3.1. хадгаламжийн сертификатыг бүртгүүлэх өргөдөл (энэ журмын хоёрдугаар хавсралт);

3.3.2. Төв банк (Монголбанк)-ны санал, дүгнэлт;

3.3.3. хаалттай хүрээнд хадгаламжийн сертификат гаргахтай холбоотой эрх бүхий этгээдийн шийдвэр;

3.3.4. биржийн бус зах зээлийн арилжаанд оруулахыг зөвшөөрсөн үнэт цаасны бүртгэлд бүртгэсэн тухай Холбооны шийдвэр;

3.3.5. хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээ, компанийн дүрэм, тусгай зөвшөөрлийн гэрчилгээний хуулбар;

3.3.6. зохицуулалтын үйлчилгээний хөлс төлсөн тухай төлбөрийн баримт.

3.4. Энэ журамд заасан баримт бичгийн бүрдэл дутуу, агуулгын хувьд зөрүүтэй, тодорхойгүй тохиолдолд Хороо нэмэлт мэдээлэл, тайлбар, тодруулга ирүүлэхийг банкнаас шаардана.

3.5. Энэ журмын 3.2, 3.3-т заасан хүсэлт гаргагчаас ирүүлсэн баримт бичгийг Хороо хүлээн авснаас хойш ажлын 20 өдрийн дотор бүртгэх эсэхийг шийдвэрлэнэ.

3.6. Банк нь харилцагчийн хүсэлтээр хадгаламжийн сертификатын тодорхой хэсгийг хугацаанаас өмнө цуцалж, бүртгэлд өөрчлөлт оруулахад дараах баримт бичгийг Хороонд ирүүлнэ:

3.6.1. хадгаламжийн сертификатын бүртгэлд өөрчлөлт оруулах хүсэлт (энэ журмын дөрөвдүгээр хавсралт);

3.6.2. хадгаламжийн сертификат нь биржийн зах зээлд бүртгэлтэй бол арилжаа эрхлэх байгууллагын шийдвэр, биржийн бус зах зээлд бүртгэлтэй бол Холбооны шийдвэр;

3.6.3. хадгаламжийн сертификатыг цуцалсан талаарх холбогдох баримт;

3.7. Хороо энэ журмын 3.6-д заасан хүсэлтийг ажлын гурван өдөрт багтаан хянаж, бүртгэлд өөрчлөлт оруулсан эсэх тухай мэдээллийг банк, үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн байгууллага, арилжаа эрхлэх байгууллага, Холбоонд албан бичгээр тус тус хүргүүлнэ.

3.8. Хороо хадгаламжийн сертификатыг дараах тохиолдолд бүртгэлээс хасна:

3.8.1. банк өөрөө хүсэлт гаргасан;

3.8.2. хадгаламжийн сертификатын хугацаа дуусгавар болсон;

3.8.3.арилжаа эрхлэх байгууллага, эсхүл Холбооны бүртгэлээс хасагдсан;

3.8.4.шүүх болон эрх бүхий төрийн байгууллагын шийдвэрээр татан буулгах шийдвэр гаргасан.

3.9.Банк нь хадгаламжийн сертификатыг бүртгэлээс хасуулахдаа дараах баримт бичгийг Хороонд ирүүлнэ:

3.9.1.хадгаламжийн сертификатын бүртгэлээс хасуулах хүсэлт;

3.9.2.арилжаа эрхлэх байгууллага, эсхүл Холбооны бүртгэлээс хассан тухай шийдвэр;

3.9.3.хадгаламжийн сертификатын хугацаа дуусаж, үндсэн болон хүүгийн төлбөрийг бүрэн төлсөн талаарх тайлан;

3.9.4.зохицуулалтын үйлчилгээний хөлс төлсөн төлбөрийн баримт.

3.10.Энэ журмын 3.8.3, 3.8.4-д заасан үндэслэлээр бүртгэлээс хасагдсан тохиолдолд банк бүртгэлээс хасагдах үеийн хадгаламжийн сертификатыг өмчлөгч тус бүрийн нэр дээр бүртгэх бөгөөд энэ талаар Хороонд мэдэгдэж, Хорооны бүртгэлээс хасуулах хүсэлтээ 1 сарын дотор гаргана.

3.11.Хороо хадгаламжийн сертификатыг бүртгэлээс хассан тохиолдолд бүртгэлээс хассан тухай шийдвэрийг банк, арилжаа эрхлэх байгууллага, үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн байгууллага, Холбоонд тус тус хүргүүлж, өөрийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлнэ.

3.12.Банк энэ журмын дагуу хадгаламжийн сертификатын бүртгэлд өөрчлөлт орсон, бүртгэлээс хасагдсан тохиолдолд энэ тухай Монголбанк, Хадгаламжийн даатгалын корпорацид ажлын гурван өдрийн дотор мэдэгдэнэ.

ДӨРӨВ.ХАДГАЛАМЖИЙН СЕРТИФИКАТЫГ БИРЖИЙН БОЛОН БИРЖИЙН БУС ЗАХ ЗЭЭЛД ХУДАЛДАХ, АРИЛЖИХ

4.1.Банк нь энэ журмын 3.5-д заасан шийдвэрийг гарсан өдрөөс хойш зургаан сарын дотор хадгаламжийн сертификатыг нийтэд, эсхүл хаалттай хүрээнд мэргэжлийн хөрөнгө оруулагчдад худалдах ажиллагааг гүйцэтгэнэ.

4.2.Банк нь энэ журмын 3.5-д заасан шийдвэр гарахаас өмнө стратегийн болон мэргэжлийн хөрөнгө оруулагчдад хадгаламжийн сертификатын талаар танилцуулж, санал болгож болно.

4.3.Банк нь хадгаламжийн сертификатыг анхдагч зах зээлд санал болгож, захиалгыг эхлүүлэх тухай мэдэгдлийг ажлын таваас доошгүй өдрийн өмнө Хороонд мэдэгдэх бөгөөд мэдэгдэл нь дараах агуулгатай байна:

4.3.1.захиалга авч эхлэх огноо, үргэлжлэх хугацаа;

4.3.2.санал болгох хадгаламжийн сертификатын хэмжээ, үнэ.

4.4.Анхдагч зах зээлийн захиалга авах үйл ажиллагаа нь ажлын таван өдрөөс илүүгүй хугацаатай байна.

4.5.Банк нь хадгаламжийн сертификатыг биржийн болон биржийн бус зах зээлд худалдсан тухай тайланг ажлын гурван өдрийн дотор Хороонд хүргүүлнэ (энэ журмын гуравдугаар хавсралт).

4.6.Хороо энэ журмын 4.5-д заасан тайланг хүлээн авч, хадгаламжийн сертификатыг амжилттай худалдсан гэж үзвэл үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн байгууллагад өмчлөх эрхийн бүртгэлийг баталгаажуулах мэдэгдлийг, арилжаа эрхлэх байгууллагад хоёрдогч зах зээлийн арилжааг эхлүүлэх мэдэгдлийг ажлын хоёр өдөрт багтаан албан бичгээр тус тус хүргүүлнэ.

4.7.Банк нь хадгаламжийн сертификат эзэмшигчийг хадгаламжийн даатгалд хамруулах зорилгоор биржийн болон биржийн бус зах зээлд гаргасан хадгаламжийн сертификатын тоо, хэмжээ, эцсийн өмчлөгч зэрэг мэдээллийг Хадгаламжийн даатгалын корпорацид улирал бүр хүргүүлнэ.

ТАВ.БАНКНЫ ЭРХ, ҮҮРЭГ

5.1.Банк нь дараах эрх, үүрэгтэй:

5.1.1.Хорооны бүртгэлд бүртгүүлэхээр гаргасан хадгаламжийн сертификатыг бүртгүүлэх хүсэлт нь хэрхэн шийдвэрлэгдэж байгаа талаарх явцын мэдээ, мэдээллээр хангагдах;

5.1.2.Хорооноос хадгаламжийн сертификатын бүртгэлтэй холбоотой аливаа мэдээлэл ирүүлэхийг шаардсан бол тодруулга, нэмэлт баримт бичгийг заасан хугацаанд Хороонд хүргүүлэх;

5.1.3.холбогдох хууль тогтоомж болон энэ журамд заасны дагуу мэдээллийн ил тод байдлыг тогтмол хангаж, хадгалуулагчийн өмнө хүлээсэн үүргээ хэрэгжүүлж ажиллах.

ЗУРГАА.МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДАЛ, ТАЙЛАГНАЛ

6.1.Банк нь жилийн болон хагас жилийн үйл ажиллагааны тайланг гаргах бөгөөд жилийн тайланг дараа жилийн 04 дүгээр сарын 30-ны өдрийн дотор, хагас жилийн тайланг дараа сарын 20-ны өдрийн дотор Хороо болон Монголбанкинд цаасан, эсхүл цахим хэлбэрээр ирүүлнэ.

6.2.Энэ журмын 6.1-д заасан жилийн болон хагас жилийн үйл ажиллагааны тайланд дараах мэдээллийг тусгана:

6.2.1.нийт хадгалуулагчийн тоо, тэдгээрийн хадгалагдаж буй сертификатын тоо;

6.2.2.хадгаламжийн сертификатын хүү, дуусах хугацаа;

6.2.3.үнэт цаасны зах зээлд арилжсан нийт сертификатын тоо, арилжааны дүн.

6.3.Монголбанк нь зайны болон газар дээрх хяналт шалгалтаар банкны зохистой харьцаа, төлбөрийн чадвар алдагдсан, эсхүл алдагдах эрсдэлтэй нь тогтоогдсон бол энэ талаар Хороонд мэдэгдэнэ.

6.4.Банк нь энэ журамд заасан мэдээллийг холбогдох журамдаа тусгаж, үйл ажиллагаандаа тогтмол мөрдөж ажиллана.

~oOo~

Хавсралт 1: Нийтэд санал болгон гаргах хадгаламжийн сертификатыг бүртгүүлэх өргөдөл

Хавсралт 2: Хаалттай хүрээнд гаргах хадгаламжийн сертификатыг бүртгүүлэх өргөдөл

Хавсралт 3: Хадгаламжийн сертификатын анхдагч зах зээлд санал болгон худалдсан тухай тайлан

Хавсралт 4: Хадгаламжийн сертификатын бүртгэлд өөрчлөлт оруулах хүсэлт

“Үнэт цаасны зах зээлд арилжихаар гаргах
хадгаламжийн сертификатыг бүртгэх,
арилжих, тайлагнах журам”-ын
нэгдүгээр хавсралт

НИЙТЭД САНАЛ БОЛГОН ГАРГАХ ХАДГАЛАМЖИЙН СЕРТИФИКАТЫГ БҮРТГҮҮЛЭХ ӨРГӨДӨЛ

Огноо:/...../.....
(0000,сс,00)

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНД

1.	Хадгаламжийн сертификат гаргагч банкны мэдээлэл	
1.1.	Оноосон нэр:	Монгол:
		Англи:
1.2.	Хуулийн этгээдийн төрөл:	<input type="checkbox"/> Нээлттэй хувьцаат компани
		<input type="checkbox"/> Хаалттай хувьцаат компани
1.3.	Улсын бүртгэлийн дугаар:	
1.4.	Регистрийн дугаар:	
1.5.	Хаяг:	
1.6.	Цахим хуудас:	
1.7.	Цахим шуудангийн хаяг:	
1.8.	Холбоо барих утас:	
2.	Хадгаламжийн сертификатын мэдээлэл	
2.1.	Хадгаламжийн сертификатын нэр:	
2.2.	Хадгаламжийн сертификатыг гаргах арилжаа эрхлэх байгууллага, бүртгүүлсэн огноо, шийдвэрийн дугаар:	
2.3.	Банкны тухай хуулийн 6.1.1-т заасан үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн огноо, дугаар:	
2.4.	Тоо ширхэг:	
2.5.	Нэрлэсэн үнэ:	
2.6.	Хүү:	
2.7.	Хугацаа:	
2.8.	Нийтээс татан төвлөрүүлэх мөнгөн хөрөнгийн хэмжээ:	

“.....” хадгаламжийн сертификат гаргагч банк бид энэхүү өргөдөлд заасан хадгаламжийн сертификатыг арилжаа эрхлэх “.....” байгууллагад бүртгүүлсэн тул Хорооны нийтэд санал болгохыг зөвшөөрсөн үнэт цаасны бүртгэлд бүртгүүлж, анхдагч зах зээлд санал болгох хүсэлтэй тул холбогдох журмын дагуу шийдвэрлэж, зохих зөвшөөрлийг олгож өгнө ҮҮ.

Өргөдөл гаргасан:

1. Овог, нэр:.....
Албан тушаал: Хадгаламжийн сертификат гаргагч
“.....”...К-ийн гүйцэтгэх захирал

Гарын үсэг:.....

(Тамга/тэмдэг)

2. Овог, нэр:.....
Албан тушаал: Хадгаламжийн сертификат гаргагч “.....” ...К-ийн Ерөнхий нягтлан бодогч

Гарын үсэг:.....

(Тамга/тэмдэг)

Өргөдөлтэй холбоотой асуудлыг хариуцан ажиллах ажилтны овог нэр, албан тушаал, холбоо барих утас, цахим шуудан:

ТУСГАЙ ТЭМДЭГЛЭЛ (зөвхөн Санхүүгийн зохицуулах хорооны ажилтан бөглөнө)

<p>Өргөдөл хүлээн авсан ажилтны овог нэр:</p>	<p>Өргөдөл хүлээн авсан огноо, цаг, минут:</p>	<p>Өргөдөл, түүнд хавсаргасан баримтын тоо (нүүрээр):</p>
---	--	---

“Үнэт цаасны зах зээлд арилжихаар гаргах
хадгаламжийн сертификатыг бүртгэх,
арилжих, тайлагнах журам”-ын
хоёрдугаар хавсралт

ХААЛТТАЙ ХҮРЭЭНД ГАРГАХ ХАДГАЛАМЖИЙН СЕРТИФИКАТЫГ БҮРТГҮҮЛЭХ ӨРГӨДӨЛ

Огноо:/...../.....
(0000,сс,00)

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНД

1.	Хадгаламжийн сертификат гаргагч банкны мэдээлэл	
1.1.	Оноосон нэр:	Монгол:
		Англи:
1.2.	Хуулийн этгээдийн төрөл:	<input type="checkbox"/> Нээлттэй хувьцаат компани
		<input type="checkbox"/> Хаалттай хувьцаат компани
1.3.	Улсын бүртгэлийн дугаар:	
1.4.	Регистрийн дугаар:	
1.5.	Хаяг:	
1.6.	Цахим хуудас:	
1.7.	Цахим шуудангийн хаяг:	
1.8.	Холбоо барих утас:	
2.	Хадгаламжийн сертификатын мэдээлэл	
2.1.	Хадгаламжийн сертификатын нэр:	
2.2.	Биржийн бус зах зээлийн арилжаанд оруулахыг зөвшөөрсөн шийдвэрийн огноо, дугаар:	
2.3.	Банкны тухай хуулийн 6.1.1-т заасан үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн огноо, дугаар:	
2.4.	Тоо ширхэг:	
2.5.	Нэрлэсэн үнэ:	
2.6.	Хүү:	
2.7.	Хугацаа:	
2.8.	Нийтээс татан төвлөрүүлэх мөнгөн хөрөнгийн хэмжээ:	

“.....” хадгаламжийн сертификат гаргагч банк бид энэхүү өргөдөлд заасан хадгаламжийн сертификатыг “Монголын үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбоо” ГҮТББ-д бүртгүүлсэн тул Хорооны үнэт цаасны бүртгэлд бүртгүүлэх хүсэлтэй тул холбогдох журмын дагуу шийдвэрлэж өгнө үү.

Өргөдөл гаргасан:

1. Овог, нэр:.....
Албан тушаал: Хадгаламжийн сертификат гаргагч
“.....”...К-ийн гүйцэтгэх захирал

Гарын үсэг:.....

(Тамга/тэмдэг)

2. Овог, нэр:.....
Албан тушаал: Хадгаламжийн сертификат гаргагч “.....” ...К-ийн Ерөнхий нягтлан бодогч

Гарын үсэг:.....

(Тамга/тэмдэг)

Өргөдөлтэй холбоотой асуудлыг хариуцан ажиллах ажилтны овог нэр, албан тушаал, холбоо барих утас, цахим шуудан:

ТУСГАЙ ТЭМДЭГЛЭЛ (зөвхөн Санхүүгийн зохицуулах хорооны ажилтан бөглөнө)

<p>Өргөдөл хүлээн авсан ажилтны овог нэр:</p>	<p>Өргөдөл хүлээн авсан огноо, цаг, минут:</p>	<p>Өргөдөл, түүнд хавсаргасан баримтын тоо (нүүрээр):</p>
---	--	---

“Үнэт цаасны зах зээлд арилжихаар гаргах
хадгаламжийн сертификатыг бүртгэх,
арилжих, тайлагнах журам”-ын
гуравдугаар хавсралт

**ХАДГАЛАМЖИЙН СЕРТИФИКАТЫГ АНХДАГЧ ЗАХ ЗЭЭЛД
САНАЛ БОЛГОН ХУДАЛДСАН ТУХАЙ ТАЙЛАН**

Огноо:/...../.....
(0000,сс,00)

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНД

1.	Хадгаламжийн сертификат гаргагч банкны мэдээлэл		
1.1.	Оноосон нэр:		
1.2.	Хаяг:		
1.3.	Цахим хуудас:		
1.4.	Цахим шуудангийн хаяг:		
1.5.	Холбоо барих утас:		
2.	Хадгаламжийн сертификатын мэдээлэл		
2.1.	Хадгаламжийн сертификатын нэр		
2.2.	Тоо ширхэг:		
2.3.	Нэрлэсэн үнэ:		
2.4.	Хугацаа:		
2.5.	Хүү:		
3.	Анхдагч зах зээлд худалдсан хадгаламжийн сертификатын талаарх мэдээлэл		
3.1.	Анхдагч зах зээлд санал болгож эхэлсэн болон дууссан огноо:		
3.2.	Хадгаламжийн сертификат нь биржийн зах зээлд бүртгэлтэй бол арилжаа эрхлэх байгууллага, биржийн бус зах зээлд бүртгэлтэй бол Холбооны оноосон нэр:		
3.3.	Биржийн эсхүл биржийн бус зах зээлд худалдсан хадгаламжийн сертификатын тоо, нийт татан төвлөрүүлсэн мөнгөн хөрөнгийн хэмжээ:		
3.4.	Нэмэлт тайлбар, мэдээлэл (шаардлагатай бол):		
4.	Анхдагч зах зээлд хүлээн авсан саналын мэдээлэл		
	Агуулга	Иргэн	Хуулийн этгээд
	Хадгалуулагчийн тоо		
	Үнийн дүн		
	Хувь		

Тайлан гаргасан:

1. Овог, нэр:

Албан тушаал: Хадгаламжийн сертификат
гаргагч “.....” ...К-ийн гүйцэтгэх
захирал

Гарын үсэг:

(Тамга/тэмдэг)

2. Овог, нэр:

Албан тушаал: Хадгаламжийн сертификат
гаргагч “.....” ...К-ийн Ерөнхий
нягтлан бодогч

Гарын үсэг:

(Тамга/тэмдэг)

“Үнэт цаасны зах зээлд арилжихаар гаргах хадгаламжийн сертификатыг бүртгэх, арилжих, тайлагнах журам”-ын дөрөвдүгээр хавсралт

ХАДГАЛАМЖИЙН СЕРТИФИКАТЫН БҮРТГЭЛД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ХҮСЭЛТ

Огноо:/...../.....
(0000,cc,өө)

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНД

1.	Хадгаламжийн сертификатын мэдээлэл	
1.1.	Хадгаламжийн сертификат гаргагч банкны нэр:	
1.2.	Хадгаламжийн сертификатын нэр:	
1.3.	Бүртгэлтэй тоо, ширхэг:	
1.4.	Нийт үнийн дүн:	
2.	Хадгаламжийн сертификатын бүртгэлд оруулах өөрчлөлтийн мэдээлэл	
2.1.	Бүртгэлээс хасуулах хадгаламжийн сертификатын тоо, ширхэг:	
2.2.	Нийт үнийн дүн:	
3.	Хадгаламжийн сертификатын бүртгэлд өөрчлөлт оруулах болсон шалтгаан:	

Хүсэлт гаргасан:

1. Овог, нэр:

Албан тушаал: Хадгаламжийн сертификат гаргагч “.....”...К-ийн гүйцэтгэх захирал

Гарын үсэг:

(Тамга/тэмдэг)

Өргөдөлтэй холбоотой асуудлыг хариуцан ажиллах ажилтны овог нэр, албан тушаал, холбоо барих утас, цахим шуудан:

2. Овог, нэр:

Албан тушаал: Хадгаламжийн сертификат гаргагч “.....”...К-ийн Ерөнхий нягтлан бодогч

Гарын үсэг:

(Тамга/тэмдэг)

--